

ИДЛЭГ ШОНХОР ШУВУУ БАРИХ ОТОГТ ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

1. Идлэг шонхор шувууны барихаар ажиллах тээврийн хэрэгслүүд нь яамнаас өгсөн наалт тэмдгийг авто тээврийн хэрэгсэл бүрийн урд талын хаалганд нааж байрлуулах, барьсан идлэг шонхор шувууны хөлд зүүлт зүүсэн байх ёстой.

2. Зөвшөөрлөө биедээ авч явах

3. Тусгайлан хэвлэсэн наалт тэмдгийг авто тээврийн хэрэгслийн зохих хэсэг наагаагүй бол, зүүлтийг идлэг шонхор шувууны хөлд зүүгээгүй, хаяж үрэгдүүлсэн, бусдад шилжүүлсэн тохиолдолд идлэг шонхор шувуу барих ажлаар явахыг хориглох ба гэрээний заалт зөрчсөн гэж үзэж идлэг шонхор барих эрхийг цуцална.

4. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ холбогдох байгууллагаар хийлгэсэн байх.

5. Идлэг шонхор барих отог орон нутагт ажиллахаас өмнө тухай тухай аймгийн Засаг даргын газарт мэдэгдэж отог ажиллуулах талаар зөвшөөрөл авч гэрээ байгуулна.

6. Отог идлэг шонхороо барих ажлаа дуусган буух тохиолдолд тухайн сумын ЗДТГ-т мэдэгдэж, отоглосон газраа цэвэрлэн хүлээлгэн өгч, идлэг шонхор шувуу барьсан актыг тулгаж, протокол үйлдэнэ.

7. Протокол үйлдэлгүйгээр отгоо буулган явсан, байршсан газраа цэвэрлээгүй, сум орон нутгийн тавьсан шаардлага болон гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд отгийн үйл ажиллагааг зогсоож, барьсан идлэг шонхорыг хилээр нэвтрэх зөвшөөрөл олгохгүй байх арга хэмжээг төрийн захиргааны төв байгууллага авна.

8. Гэрээнд зааснаас илүү тоогоор идлэг шонхор барьсан тухай акт үйлдсэн тохиолдолд актыг хүчингүйд тооцож, хууль бусаар барьсан үйлдэлд БОХУБ, сумын цагдаа хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.